

Огноо: 2023.03.17

№ 41

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан  
хуралдуулах тухай**

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 10 цагт Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Махатма Гандийн гудамж 39, Корпорэйт конвеншн центр, Эвэнт холл-д хосолсон /танхим болон зайнаас/ хэлбэрээр зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга /Э.Уянга/-д даалгасугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг “Төрийн банк” ХК, Хөрөнгийн биржийн цахим хуудсаар болон өдөр тутмын хоёроос доошгүй сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн дотор нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д даалгасугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөр тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гаргах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралтай холбогдох бусад баримт бичгийг 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер дилерийн компанид хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д даалгасугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын нийтэд хүргэх зарын загварыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг 3 дугаар хавсралтаар баталсугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудасны загварыг 4 дүгээр хавсралтаар баталсугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах Комиссыг 5 дугаар хавсралтад заасан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын Комиссыг 6 дугаар хавсралтад заасан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хосолсон хэлбэрээр зохион байгуулахад шаардлагатай цахим шийдлийг бүрдүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д даалгасугай.

13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалтай танилцах боломжийг хувьцаа эзэмшигч бүрд олгох нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д даалгасугай.

14. Хувьцаа эзэмшигчдийн саналыг урьдчилсан байдлаар 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 15 цаг хүртэл хугацаанд брокер дилерийн компаниар дамжуулан эсхүл Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо 7/1 хаягт байрлах “Төрийн банк” ХК-ийн төв байр, орон нутагт дахь салбар нэгжүүдэд цаасан болон цахим хэлбэр /www.statebank.mn/-ээр урьдчилан авах боломжийг бүрдүүлж ажиллахыг Зохион байгуулах комисс /Д.Сугар/-т даалгасугай.

15. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсыг цаасан болон цахим хэлбэрээр авч, нэгдсэн тооллогын үр дүнг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, шийдвэрлүүлэхийг Тооллогын комисс /А.Батмөнх/-т даалгасугай.

16. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Сангийн дэд сайд /С.Мөнгөнчимэг/-ыг томилсугай.

17. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад журамд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга /Э.Уянга/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ТЭЛМҮҮН